



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/271

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тусгасан “Авто тээврийн төвийн барилгын засвар” ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “Гурван уулын хишиг” ХХК-тай 29,135,324 (Хорин есөн сая нэг зуун гучин таван мянга гурван зуун хорин дөрвөн) төгрөгөөр гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

2.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Гурван уулын хишиг” ХХК-ийн захирал (Д.Мягмардорж)-д үүрэг болгосугай.

3.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

4.Дээрх хөрөнгө оруулалтын ажлыг данс бүртгэлд тусгаж ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Авто тээврийн төвийн дарга (Н.Баасанжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



ОЧ дүгээр сарын 24-ний өдрийн А/24/ дугаар
Аймгийн Засаг даргын 2024 оны
захирамжийн хавсралт

Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Д.Батцогт
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Д.Батцогт
3	Магадалшгүй ажил	490 282	Ү.Бямбасүрэн
4	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	245 141	Ү.Бямбасүрэн
5	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	900 000	Ү.Бямбасүрэн
6	Нормчлолын сан	44 125	Ү.Бямбасүрэн
7	Захиалагчийн техник хяналтын зардал	490 282	Ү.Бямбасүрэн
8	Ажлыг хийж гүйцэтгэх хугацаа	20 хоног	Ү.Бямбасүрэн